



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Аудитын код: ДГА-2020/81/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2020 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: [ariunaa.ch@audit.gov.mn](mailto:ariunaa.ch@audit.gov.mn)

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: [enkhtsetsteg.e@audit.gov.mn](mailto:enkhtsetsteg.e@audit.gov.mn)

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70503020 Цахим хаяг: [uranbileg.b@audit.gov.mn](mailto:uranbileg.b@audit.gov.mn)

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
Менежментийн захидал .....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	19

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

САЙХАНДУЛААН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Т.ГАНБАТ ТАНАА

2020.02.21 № 1-6/108  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2.1. Оршил

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Т.Ганбатад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 13-аас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 13-ний өдөр 3/27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна. Ирүүлсэн албан бичгийг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ирүүлснээр тэмдэглэсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд оновчтой бодлого зохицуулалтаар хангах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэх” гэж тусгасан байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 276869.8 мянган төгрөгөөс тооцон 2768.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 3458.8 мянган төгрөгөөр тооцсон нь аудитын төлөвлөлтийн үе шатанд 1 хувиар тооцсоныг өөрчлөөгүйтэй холбоотой болно. /шалтгааныг бичих/

#### **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 233623.6 мянган

төгрөгөөр буюу 16 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	17,138.6	22,549.8	5,411.2
Үндсэн хөрөнгө	1,184,260.3	1,376,189.7	191,929.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,201,398.9</b>	<b>1,398,739.5</b>	<b>197,340.6</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,201,398.9	1,398,739.5	197,340.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,201,398.9</b>	<b>1,398,739.5</b>	<b>197,340.6</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тухайн жилийн түлш шатахууны зардлын үлдэгдлээс 4595.7 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй байна. Мөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1170.0 мянган төгрөгийн авсан аж ахуйн материалыг байгууллагын данс бүртгэлд тусгасан байна. Аймгийн Гал унтраах ангиас 4539.5 мянган төгрөгийн бэлэн байдлын үйл ажиллагаанд зориулж аж ахуйн материал хандиваар авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дүн 191929.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1150.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 10000.0 мянган төгрөгийн барилгын сайжруулалт, 114972.1 мянган төгрөгийн дуусаагүй барилга дансанд, ОНХС, ОНХО-аар 72174.5 мянган төгрөгийн автомашин шинээр бүртгэгдэж, 15800.0 төгрөгийн автомашиныг балансаас балансад шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1398739.5 мянган төгрөг болж өссөн тайлант жилийн үр дүнтэй холбоотой байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газар тайлант онд 195906.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 196800.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100.5 хувиар биелүүлсэн байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын 50 хувийг орон нутгийн төсөвт шилжүүлэн, орлогыг бууруулсан дүнгээр тайлагнаснаас орлогын дүн буурч тайлагнагдсан.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орон нутгийн төсвөөс санхүүжих	275869.8	275869.8	-	100
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1000.0	693.7	306.4	69.4
<b>Нийт дүн</b>	<b>276869.8</b>	<b>276563.5</b>	<b>306.4</b>	<b>99.8</b>

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 276869.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 276869.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 276563.5 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг төлөвлөсний дагуу зарцуулсантай холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Тайланд онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 11963.9 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна. Зарцуулалтыг авч үзвэл өвс тэжээл борлуулсны орлого 5847.7 мянган төгрөг, тендерийн баримт бичгийн үнэ 346.5 мянган төгрөг, ШШГГ-аас буцаан олголтын 200.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс 239.2 мянган төгрөгийн малын нөхөн олговрын зардал, аймгийн ХХААГ-аас малын цэцэг өвчний зардал болох 3574.3 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 2103.7 мянган төгрөгийн мал тооллогын зардлыг тус тус төвлөрүүлэн холбогдох зардалд зарцуулсан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3170.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 43.6 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 311.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 2815.7 мянган төгрөгийг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 354.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 354.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага тогтоож хүргүүллээ. Үүнд:

### 2.11.1 Зардлын данстай холбоотой асуудал

Тайлант онд байгууллагын нягтлан бодогчийн ээлжийн амралтын тооцооллыг хийхдээ 2018 оны 9-12 сарын ажилласан хоногийг 1-6 хоногоор дутуу оруулж тооцсоноос нийт 43.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчилд илүү олгосон ээлжийн амралтын олговрыг төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

### 2.11.2 Зардлын данстай холбоотой асуудал

Тайлант онд байгууллагын нярав Ч.Чойбаатарын үндсэн цалинг сумын Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/04 дугаар тушаалаар ТҮ-4-5 шатлалаар буюу 547164 мянган төгрөгөөр цалинжуулахаар тогтоосон байхад нягтлан бодогч цалинг 521487 төгрөгөөр бодож олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “дансны өглөг, авлага ба өр төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчилд тооцсон дүнгээр албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 17 төрлийн мэдээлэл мэдээлэхээс 15 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 2019 оны 11-12 сард мэдээлээгүй, шилэн дансны цахим системийг хөтлөөгүй байна.

## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 582.3 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### *1. Балансын данстай холбоотой асуудал*

##### *1.1. Илрүүлэлт:*

2019 онд бараа материалын нормын хувцас, зөөлөн эдлэл данснаас нийт 0.3 сая төгрөгийн үнэ бүхий аранз, гамшгийн хувцас, нормын хувцсыг байгууллагын даргын тушаал, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтгүйгээр акталсан байна. Энэ нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1-д “... худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх” гэж заасныг зөрчсөн байна.

##### *1.2. Эрсдэл:*

Төсвийн хөрөнгийг холбогдох шийдвэргүйгээр акталж устгах, хөрөнгө завших эрсдэлийг бий болгож байна.

##### *1.3. Өгсөн зөвлөмж:*

Үндсэн хөрөнгө, бараа материалыг актлах, устгах тохиолдолд холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж, байгууллагын даргын тушаалаар баталгаажуулснаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.

## *2. Зардлын данстай холбоотой асуудал*

### 2.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын 2019 оны ажил гүйлгээг шалгахад батлагдсан төсвөөс 2457.0 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчиж, бүртгэж, тайлагнасан байна. Тухайлбал: Бичиг хэргийн зардлаас аудитын төлбөр, дахин үнэлгээний төлбөр, санхүүгийн программын лицензийн төлбөр, хичээл үйлдвэрлэлийн зардлаас шагналын зардал, тавилга эд хогшил, бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалын зардлаас принтер, ус буцалгагч зэрэг хөрөнгө худалдан авахад зарцуулсан байна. Энэ нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2006 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ыг тус тус зөрчсөн байна.

### 2.2. Эрсдэл:

Төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна.

### 2.3. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасны дагуу батлагдсан зориулалтаар, Сангийн сайдын 2006 оны 55 дугаар тушаалаар батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ /төгрөг/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,138,553.24	22,549,819.00
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
3121	Төгрөг	0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,138,553.24	22,549,819.00
354	Хангамжийн материал	17,138,553.24	22,549,819.00
35410	Бичиг хэргийн материал	1,185,920.00	1,715,864.00
35420	Аж ахуйн материал	7,145,883.24	10,075,885.00
35440	Түлш шатах тослох материал	3,919,350.00	4,595,670.00
35470	Бусад хангамжийн материал	4,887,400.00	6,162,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,184,260,305.03	1,376,189,688.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,184,260,305.03	1,376,189,688.77
392	Биет хөрөнгө	1,163,290,905.03	1,355,297,788.79
39201	Барилга, байгууламж	680,795,534.55	690,795,534.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,151,200.04)	(16,961,142.28)
39203	Авто тээврийн хэрэгсэл	169,110,200.00	225,484,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,992,881.79)	(9,647,881.79)
39205	Машин, тоног төхөөрөмж	98,203,220.01	127,485,470.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(42,192,392.10)	(52,204,803.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,374,615.00	38,294,615.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,357,439.89)	(34,163,099.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	445,894,640.50	464,969,390.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(177,428,391.21)	(193,762,125.09)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	114,972,131.00
39217	Номын фонд	35,000.00	35,000.00
393	Биет бус хөрөнгө	20,969,400.00	20,891,899.98
39301	Програм хангамж	1,163,800.00	1,163,800.00
39302	Хасагдуулга	(312,600.00)	(390,100.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,578,200.00	20,578,200.00
39304	Хасагдуулга	(460,000.00)	(460,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,201,398,858.27	1,398,739,507.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	(0.00)	(0.00)
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	(0.00)
413	Өглөг	(0.00)	(0.00)
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	(0.00)
4136	Бусад өглөг	(0.00)	-
41361	Байгууллагад төлөх өглөг	(0.00)	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,201,398,858.27	1,398,739,507.77
51	Засгийн газрын хувь оролцоо	1,201,398,858.27	1,398,739,507.77
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	552,882,366.47	552,882,366.47
51101	Өмч: -Төрийн өмч	552,882,366.47	552,882,366.47
512	Хуримтлагдсан үр дүн	289,819,084.86	487,159,734.36
51210	Өмнөх үеийн үр дүн	289,819,084.86	289,819,084.86
51220	Тайлант үеийн үр дүн	-	197,340,649.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	358,697,406.94	358,697,406.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,201,398,858.27	1,398,739,507.77

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ДАНС	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	339,016,565.00	542,510,542.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,524,547.00	129,704,685.00
120	Нийтлэг татварын бус орлого	95,524,547.00	129,704,685.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	95,524,547.00	129,704,685.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,304,000.00	693,650.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,859,547.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76,361,000.00	129,011,035.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	243,492,018.00	412,805,857.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	237,564,750.00	275,869,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	237,564,750.00	275,869,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,963,926.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,963,926.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	124,972,131.00
1330	Төсвийн захирагчдаас	-	124,972,131.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	5,927,268.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,927,268.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	299,897,382.82	332,529,892.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	299,897,382.82	332,529,892.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	293,698,784.82	330,546,287.07
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	172,812,437.00	193,332,644.61
210101	Цалин	169,792,437.00	193,332,644.61
210104	Урамшуулал	3,020,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,305,212.00	23,276,000.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	13,707,308.00	15,827,600.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,662,200.00	1,862,100.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,329,400.00	1,489,700.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	332,900.00	372,400.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,273,404.00	3,724,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,869,499.00	9,080,140.00
210301	Гэрэл цахилгааны зардал	1,612,700.00	1,610,300.00
210302	Түлш, халаалтын зардал	8,256,799.00	7,369,840.00
210303	Цэвэр, бохир усны зардал	-	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,501,656.00	27,608,238.24
210401	Бичиг хэргийн материал	3,303,565.00	4,135,256.00
210402	Тээвэр, шатахууны зардал	16,713,680.90	17,130,979.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	1,681,259.00	2,649,820.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	803,151.10	1,132,750.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	-	1,928,528.24
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	630,905.00
2105	Нормативт зардал	-	363,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	363,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,593,210.00	2,936,240.00
210604	Урсгал засвар	3,593,210.00	2,936,240.00
2107	Томилолт, зочны зардал	3,398,900.00	9,895,258.00
210702	Дотоод томилолтын зардал	3,398,900.00	9,895,258.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,368,769.00	2,488,708.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550,300.00	1,053,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	171,000.00	203,500.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	234,350.00	734,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	293,119.00	417,408.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000.00	80,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,849,101.82	61,565,358.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,043,951.00	16,131,111.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	580,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,805,150.82	44,854,247.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,198,598.00	1,983,605.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,927,268.00	754,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,927,268.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	754,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	271,330.00	1,172,605.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	271,330.00	1,172,605.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	-	57,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	57,000.00

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	39,119,182.18	209,980,649.54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	375,621,158.29	12,640,000.04
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	310,468,073.16	12,640,000.04
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	65,153,085.13	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(375,621,158.29)	(12,640,000.04)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(336,501,976.11)	197,340,649.50

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	262,655,565.00	288,527,376.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,163,547.00	693,650.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,163,547.00	693,650.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	19,163,547.00	693,650.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,304,000.00	693,650.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,859,547.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	243,492,018.00	287,833,726.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	237,564,750.00	275,869,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	237,564,750.00	275,869,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,963,926.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,963,926.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,927,268.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,927,268.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	262,655,565.00	287,377,376.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,655,565.00	287,377,376.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	256,456,967.00	285,347,770.61
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	173,595,646.00	193,260,284.61
210101	Үндсэн цалин	170,575,646.00	193,260,284.61
210104	Үр дүнгийн урамшуулал	3,020,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,307,512.00	23,276,000.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	13,707,308.00	15,827,600.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,662,200.00	1,862,100.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,329,400.00	1,489,700.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	332,900.00	372,400.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,275,704.00	3,724,200.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	10,210,549.00	10,136,460.00
210301	Гэрэл цахилгааны зардал	1,610,300.00	1,610,300.00
210302	Түлш, халаалтын зардал	8,480,249.00	8,426,160.00
210303	Цэвэр, бохир усны зардал	120,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,623,141.00	19,964,320.00
210401	Бичиг хэрэг	3,227,220.00	3,586,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,198,602.00	12,896,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,962,789.00	2,674,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,834,530.00	357,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	450,000.00
2105	Нормативт зардал	730,040.00	200,000.00
210502	Хоол, хүнс	530,040.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,785,310.00	1,579,990.00
210601	Багаж техник хэрэгсэл	5,000,000.00	-
210604	Урсгал засвар	2,785,310.00	1,579,990.00
2107	Томилолт, зочны зардал	3,398,900.00	9,895,258.00
210702	Дотоод албан томилолт	3,398,900.00	9,895,258.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,393,769.00	9,759,058.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	575,300.00	8,323,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	171,000.00	203,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	234,000.00	734,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	293,469.00	417,408.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	80,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,412,100.00	17,276,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,412,100.00	15,976,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,198,598.00	2,029,605.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,927,268.00	800,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	5,927,268.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	271,330.00	1,172,605.39

	санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	271,330.00	1,172,605.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	57,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	57,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	1,150,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	1,150,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,150,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,150,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,150,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(1,150,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	ДАНС	511.00	51,300.00	51210+51220	
C01	2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	532,764,166.47	-	581,827,687.83	1,114,591,854.30
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	53,642,182.84	53,642,182.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	532,764,166.47	-	635,469,870.67	1,168,234,037.14
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	20,118,200.00	-	(336,501,976.11)	(316,383,776.11)
C08	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	552,882,366.47	358,697,406.94	289,819,084.86	1,201,398,858.27
D01	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	552,882,366.47	358,697,406.94	289,819,084.86	1,201,398,858.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	552,882,366.47	358,697,406.94	289,819,084.86	1,201,398,858.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	197,340,649.50	197,340,649.50
D09	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	552,882,366.47	358,697,406.94	487,159,734.36	1,398,739,507.77

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/					
ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	276,869,800.00	276,563,450.00	306,350.00	99.89
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	276,869,800.00	276,563,450.00	306,350.00	99.89
210	Бараа, үйлчилгээний зардал	276,069,800.00	274,590,844.61	1,478,955.39	99.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,283,800.00	193,260,284.61	23,515.39	99.99
210101	Үндсэн цалин	193,283,800.00	193,260,284.61	23,515.39	99.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,276,000.00	23,276,000.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	15,827,600.00	15,827,600.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,862,100.00	1,862,100.00	-	100.00
210203	ҮОМШӨ ний даатгал	1,489,700.00	1,489,700.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	372,400.00	372,400.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,724,200.00	3,724,200.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,210,300.00	10,136,460.00	73,840.00	99.28
210301	Гэрэл цахилгаан	1,610,300.00	1,610,300.00	-	100.00
210302	Түлш, халаалт	8,500,000.00	8,426,160.00	73,840.00	99.13
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,967,700.00	18,934,220.00	33,480.00	99.82
210401	Бичиг хэрэг	3,244,300.00	3,239,900.00	4,400.00	99.86
210402	Тээвэр (шатахуун)	11,662,900.00	11,662,900.00	-	100.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,700,500.00	2,674,320.00	26,180.00	99.03
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	357,100.00	2,900.00	99.19
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00	-	100.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	1,580,000.00	1,579,990.00	10.00	100.00
210604	Урсгал засвар	1,580,000.00	1,579,990.00	10.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	7,577,200.00	6,321,000.00	1,256,200.00	83.42
210702	Дотоод албан томилолт	7,577,200.00	6,321,000.00	1,256,200.00	83.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,074,800.00	3,994,858.00	79,942.00	98.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,572,000.00	2,559,150.00	12,850.00	99.50
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	230,000.00	203,500.00	26,500.00	88.48
210803	Даатгалын үйлчилгээ	734,800.00	734,800.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	417,408.00	32,592.00	92.76
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	80,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	8,000.00	-	8,000.00	-
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	16,900,000.00	16,888,032.00	11,968.00	99.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,988,032.00	11,968.00	99.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,900,000.00	-	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	1,972,605.39	(1,172,605.39)	246.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	800,000.00	800,000.00	-	100.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,172,605.39	(1,172,605.39)	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,172,605.39	(1,172,605.39)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	276,869,800.00	276,563,450.00	306,350.00	99.89
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	275,869,800.00	275,869,800.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	275,869,800.00	275,869,800.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	693,650.00	306,350.00	69.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	693,650.00	306,350.00	69.37
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-	-	-
620001	Удирдах ажилтан	-	-	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	-
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	-	-	-	-

#### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	11,963,926.00	(11,963,926.00)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	11,963,926.00	(11,963,926.00)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	11,906,926.00	(11,906,926.00)	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,580,100.00	(1,580,100.00)	-
210401	Бичиг хэрэг	-	346,500.00	(346,500.00)	-
210402	Тээвэр (шатахуун)	-	1,233,600.00	(1,233,600.00)	-
2107	Томилолт, зочны зардал	-	3,574,258.00	(3,574,258.00)	-
210702	Дотоод албан томилолт	-	3,574,258.00	(3,574,258.00)	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	5,764,200.00	(5,764,200.00)	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	5,764,200.00	(5,764,200.00)	-
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	988,368.00	(988,368.00)	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	988,368.00	(988,368.00)	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	57,000.00	(57,000.00)	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	57,000.00	(57,000.00)	-
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	57,000.00	(57,000.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	11,963,926.00	(11,963,926.00)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,963,926.00	(11,963,926.00)	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,963,926.00	(11,963,926.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-	-	-
620001	Удирдах ажилтан	-	-	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	-
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	-	-	-	-